



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 52

Арвайхээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 ж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтууыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах төсвийг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.



ДАРГА

А.ИШДОРЖ

100130105

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 07 дугаар сарын 02 -ны өдрийн
58 дугаар тогтоолын хавсралт



АРВАЙХЭЭР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Арвайхээр хотын хүн ам өсч, суурьшлын бүс нэмэгдэж байгаагийн улмаас хүрээлэн байгаа орчны бохирдол ихэсч энэ нь байгаль орчин төдийгүй аймаг орон нутгийн нийгмийн хөгжил, хүний амьдрах орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд Арвайхээр хотын агаарын бохирдол нэмэгдэж, ялангуяа өвлийн улиралд Арвайхээр хотын агаарын бохирдлын хэмжээ, хүхэрлэг хийн агууламж, том ширхэгт тоосонцорын хэмжээ хэт ихэсч, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Суурийн эх үүсвэрээс ялгарах хорт бодисын агууламжийг Жайка олон улсын байгууллагын судалгааны аргачлалаар тооцоолоход агаарын бохирдлын 60% нь гэр хорооллоос, 40% нь халаалтын зуухнуудаас ялгарч байна.

Аймгийн УЦУОШТ-ийн Байгаль орчны шинжилгээний лаборатори хүхэрлэг хий, азотын давхар ислийг 20 минутын дундаж агууламжаар хөтөлбөрийн дагуу хоногт 2-3 удаа, том ширхэгт тоосонцорын агууламжийг 7 хоногт 1-2 удаа 24 цагийн дундаж агууламжаар тодорхойлдог.

Шинжилгээний дүнгээс үзэхэд агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байна. 10,11,12,1,2,3 дугаар саруудад хүхэрлэг хийн хэмжээ бусад сарынхаас их байна. Хүхэрлэг хий нь хүхэр агуулсан нүүрс түлснээс үүсдэг ба гол эх үүсвэр нь манай аймгийн хувьд олон жижиг халаалтын зуухнууд, гэр хороолол байдаг учир галлагаа зогссон зуны улиралд буурч, өвлийн улиралд өсч байгаа нь харагдаж байна.

2018 онд хийсэн хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжилт шинжилгээний дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй бөгөөд урд онуудтай харьцуулахад 2-6 мкг/м³-р ихэссэн байна. Хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 1-41 мкг/м³, 11-12 дугаар саруудад бусад сарын дундаж агууламжаас бохирдол их байна.

Азотын давхар ислийн сарын дундаж агууламж 15-50 мкг/м³, 01-03 сард бусад сарын дундаж агууламжаас их бохирдолтой байна. Азотын давхар ислийн хоногийн хамгийн их нь 1 сард 289 мкг/м³ байна. Азотын давхар ислийн жилийн дундаж агууламжийг урд онуудтай харьцуулахад 24-31 мкг/м³-д хэлбэлзэж дундаж агууламж 31 мкг/м³ байгаа нь урд онуудаас 2-7 мкг/м³-р ихэссэн байна.

Орчны том ширхэгт тоосонцор /PM10/-ын хэмжилтийг стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас 01-02 дугаар сар, 11-12 дугаар саруудад 1.1-2.2 дахин давсан бохирдолтой, жилийн дундаж агууламж 1.3-2.1 дахин давсан бохирдолтой байна.

Арвайхээр хотод байгаа агаарын болон орчны бохирдлын эх үүсвэрүүд нь : 2018 оны эх үүсвэрийн нэгдсэн тооллогын дүнгээр 10 квт хүртэлх хүчин чадалтай эх үүсвэр – 6147 /айл өрх/, 11-100 квт-ын хүчин чадалтай эх үүсвэр-125 /бага оврын халаалтын зуух/, 101 квт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэр-50 /том оврын халаалтын зуух / авто тээврийн хэрэгсэл 10114 байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөрээс ялгаран гарч буй утаа нь хүний амьсгалах түвшинд ойр зайд буюу 0.2 м өндөрт цацагддаг бөгөөд түүний найрлагад хүний амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн системийн эрхтний үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боох, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй нүүрстөрөгчийн исэл, азотын исэл, нүүрс устөрөгч, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, бенз-/a/-пирен, альдегид зэрэг 200 гаруй төрлийн хорт бодис агуулж байдаг.

Уурын зуухнуудын техник технологи муудаж хуучирснаас дутуу шаталт явагддаг, утаа шүүх төхөөрөмж ашигладаггүй, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд нам даралтын зуухаар дулаан хангамжийн асуудлаа шийдвэрлэж байгаа шалтгаанаас агаарт ялгарах хорт бодисын хэмжээ ихэссээр байна.

Өвөрхангай аймгийн нийт хүн амын 25 гаруй хувь нь амьдардаг Арвайхээр хотын агаарын бохирдол сүүлийн жилүүдэд нэмэгдэж, өвлийн улиралд тогтмол утаан хөшиг тогтож, амьсгалын замаар хүний бие, эрүүл мэндэд шууд нөлөөлж байгаа зэрэг шалтгаан нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоог багасгах, сөрөг нөлөөллийг бууруулах, дэд бүтцийн байгууламжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр хорооллын ахуйн хэрэглээнд, халаалтын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлах замаар агаарын бохирдлыг бууруулж эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Агаар бохирдуулагч томоохон эх үүсвэрүүдийн агаарын чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг багасгах;

2.2.2. Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бууруулах;

2.2.3 Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, газар зохион байгуулалттай уялдуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар тоосжилт, бохирдлыг бууруулах;

2.2.4. Агаарын бохирдлыг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлыг өргөжүүлэх;

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

3.1. Хөтөлбөрийг 2019-2022 оны хооронд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

4.1. Агаар бохирдуулагч томоохон эх үүсвэрүүдийн агаарын чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг багасгах зорилтын хүрээнд:

4.1.1. Агаар бохирдуулагч аж ахуй нэгж байгууллагуудын халаалтын зуухны янданд стандартын шаардлагад нийцсэн шүүлтүүр суурилуулж, агаарт хаягдах бохирдуулагч бодисын хэмжээг багасгах;

4.1.2. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа халаалтын зуухнуудыг үе шаттайгаар нэгтгэх, төвлөрсөн дулаан хангамжид холбох;

4.1.3. Стандартын шаардлага хангахгүй байгаа халаалтын зуухнуудын үйл ажиллагааг зогсоох;

4.1.4. Халаалтын зуухнуудыг нүүрс хадгалах агуулах болон зуухнаас гарах нарийн ширхэгт тоос, үнсийг агаарт тархахаас сэргийлж дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

4.2. Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бууруулах зорилтын хүрээнд;

4.2.1. Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж, аж ахуй нэгж, айл өрхийг стандартад нийцсэн сайжруулсан түлшээр үе шаттайгаар хангах;

4.2.2. Арвайхээр хотын гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгжийг 1-3 фазын смарт тоолуураар хангаж, цахилгаан халаагуураар халаалтаа шийдэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.3. Арвайхээр хотын агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн тогтоож, мөрдүүлж ажиллах;

4.3 Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, газар зохион байгуулалттай уялдуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар бохирдол, тоосжилтыг бууруулах зорилтын хүрээнд;

4.3.1. Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, төвлөрсөн системд холбогдох боломжтой амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж эхлэх;

4.3.2. Хямд өртөгтэй нийтийн орон сууц барих санал санаачлагыг газар олголт, инженерийн дэд бүтцээр дэмжиж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4.3.3. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар ус, хөрсний бохирдлыг бууруулах;

4.3.4. Гэр хорооллын айл өрхийн үнс, хог хаягдлыг хадгалах зориулалтын цэг болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх машин механизмын тоог нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хог хаягдлыг ашиглах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих;

4.3.5. Сонгогдсон байршилд ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ноогдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;

4.3.6. Төвийн болон гэр хорооллын замуудыг үе шаттайгаар хатуу хучилттай болгож өргөтгөх;

4.3.7. Үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагууд ойр орчмын 50 м хүртэл нийтийн эзэмшлийн талбайд арчилгаа цэвэрлэгээг тогтмол хийх, зүлэг мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, явган хүний зам, авто машины зогсоолыг сайжруулах замаар тоосжилтийг бууруулах

4.3.8 Барилга байгууламж гэр, орон сууцны барилгын дулаалгын материалын технологийг сайжруулах

4.4. Агаарын бохирдлыг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд;

4.4.1. Агаарын бохирдлыг бууруулахад идэвх санаачилгатай, ажилласан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах, дэмжих, үйл ажиллагааг нь сурталчлах;

4.4.2. Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, иргэд, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах;

4.4.3. Агаар, орчны бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд учруулж байгаа урт болон богино хугацааны сөрөг нөлөөллийг тандан судалж, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга барилыг төлөвшүүлж, агаар, орчны бохирдлын улмаас үүсэх өвчлөлийг бууруулах;

4.4.4. Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр хаягдлын тооллого явуулж, бүртгэл мэдээллийн санг шинэчлэх;

4.4.5. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэг сүлжээг өргөтгөж, мэргэжлийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах гадаад, дотоодын сургалтад хамруулах, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Арвайхээр сумын инженерийн дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, агаар орчныг бохирдуулагч эх үүсвэрийн нөлөөллийг багасгаж, сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлснээр агаарын бохирдлыг 2022 онд 50 хувиар бууруулна.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2018 оны жилийн эцсийн агаарын чанарын үзүүлэлтүүдийг суурь үзүүлэлт болгон ашиглана.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэлийн хяналт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Арвайхээр сумын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг орон нутгийн түвшинд аймаг, сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв хамтран хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

7.1.1. Агаарын чанарыг сайжруулах арга хэмжээнд зориулан улс, орон нутгийн жил бүрийн төсвөөс гаргах хөрөнгө

7.1.2. Шинээр байгуулж байгаа болон ажиллаж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгө

7.1.3. Хандивлагч орон олон улсын байгууллагын зээл техникийн болон буцалтгүй тусламж хандивын хөрөнгө

7.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдийн хандивын хөрөнгө

Найм. Хамтын ажиллагаа

8.1. Хөтөлбөрийг Арвайхээр сумын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд агаарт гаргах бохирдуулах бодисын хэмжээ, найрлагыг хэмжих өргөн боломж бүхий орчин үеийн техник, технологи, тоног төхөөрөмжөөр хангах, арга зүй, аргачлал эзэмших, нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлдэх чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана.

8.3. Байгаль хамгаалах үйлсэд зориулагдсан сан, гадаад орны төсөл, зээл, тусламж, хандивын хөрөнгөөс агаарын чанарыг хамгаалах ажилд хувиарлан, оновчтой зарцуулна.

8.4. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээг 2 жил тутамд, хөндлөнгийн үнэлгээг 4 жилд мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.